

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж:

1. Асуулт даалгавар бүрийг дуустал, анхааралтай уншиж гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

1. нь олон түвшинт, нарийн нийлмэл бүтэц, зохион байгуулалт, оршин тогтнол, өөрчлөлт, хөгжил бүхий амьд организм лугаа өөрөө хөгжигч, хүнийг хөгжүүлэгч тогтолцоо мөн. \1 оноо\
A. Нийгэм
B. Соёл
C. Улс үндэстэн
D. Иргэншил
E. Нийгмийн тогтолцоо
2. Аль нь буруу бодомж вэ? \1 оноо\
A. Нийгэм бол хүний оюун ухаан, ухамсраас үл хамааран орших орчлон ертөнцийн юмсын тусгал дээд түвшин юм
B. Нийгэм бол хүний амьдралын хэрэгцээт материаллаг болон оюуны үнэт зүйлсээ бүтээж, хэрэглэж, амь нас, эрүүл мэндээ хамгаалж, үр удмаа үлдээн амьдрах зайлшгүй орчин юм
C. Нийгэм бол хүмүүс, ухамсартайгаар бүтээж, хувирган өөрчилж байгаа бодит байдал, орчлон ертөнцийн юмс, үзэгдлийн дээд хэлбэр, түвшин юм
D. Нийгэм бол гэрээ хэлцэл, хэм хэмжээ, нэгэн хүсэл сонирхол зэргээр зохицуулагдаж байдаг
E. Нийгэм бол хүн төрөлхтний амьдралын эрхэм үнэт ололт, түүний тогтвортой байдал, хөгжил цэцэглэл, аюулгүй байдлын баталгаа болдог
3. Нэг зорилго, нэг ижил эрх ашиг, сонирхол, үнэт зүйл, зан үйл бүхий хүмүүсийн нэгдлийг юу гэж тодорхойлох вэ? \1 оноо\
A. Нийгмийн нийтлэг
B. Нийгмийн бүлэг
C. Нийгмийн давхраа
D. Нийгмийн харилцаа
E. Ястан угсаатан
4. Монгол улсын ядуурлын түвшин 2010 онд нийт хүн амын 39,2 хувь байсан бол 2012 онд 29,8 хувь болж буурсан байна. Энэ өгөгдөл нь нийгмийн амьдралын аль хүрээг илэрхийлэх вэ? \1 оноо\
A. Эрх зүйн хүрээ
B. Социаль /нийгмийн/ хүрээ
C. Улс төрийн хүрээ
D. Соёл-оюун санааны хүрээ
E. Эдийн засгийн хүрээ
5. Аль нь зөв бэ? \1 оноо\
A. Иргэний нийгэм бол төр өөрийгөө илэрхийлэх хүрээ юм
B. Иргэний нийгэм бол төрийн үүрэг, оролцоо их байдаг нийгэм юм
C. Иргэний нийгэм бол төрийн байгууллагуудын нийлбэр цогц юм
D. Иргэний нийгэм бол нийгэм дэх төрөөс хараат бүх харилцаа юм
E. Иргэний нийгэм бол нийгэм дэх төрийн бус бүх төрлийн харилцаа юм
6. Анх эртний Египетэд үүссэн бөгөөд анжисыг боловсронгуй болгож, мөн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн өсөж, илүү /нэмүү/ бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь худалдаа, гар урлалыг хөгжүүлж, хот үүсэх боломж олгожээ. Энэ нь нийгмийн аль хэв маяг вэ? \1 оноо\
A. Агнуурын болон түүвэрлэгчдийн нийгэм
B. Аж үйлдвэржсэн нийгэм
C. Цэцэрлэгийн аж ахуйн буюу энгийн тариалангийн нийгэм
D. Газар тариалангийн нийгэм
E. Аж үйлдвэржсэний дараах нийгэм
7. Нийгмийн институтуудын шууд хамаарагдах харилцаануудад буруу холбоос орсон бол аль нь вэ? \1 оноо\
A. Гэр бүлийн институт - Эцэг, эх - Бөгж, зүүлт
B. Боловсролын институт - Багш, лам - Зар суртчилгаа, марк
C. Улс төрийн институт - Хууль тогтоомж, эрх зүйн субъект - Далбаа, хуулийн эмхэтгэл
D. Эдийн засгийн институт - Ажил олгогч, хөлсний ажилчин - Мөнгөн тэмдэгт, худалдаа
E. Шашны институт - Хамба, гэсгүй - Судар, загалмай

8. Нийгэмд хүлээн зөвшөөрч буй зоримжууд, зан заншил, дэг журмыг аль ойлголтоор тэмдэглэж болох вэ? \1 оноо\
- A. Нийгмийн үүрэг
D. Институтчлэл
- B. Институц
E. Шинжлэх ухааны институт
- C. Институт
9. Аж үйлдвэржсэн нийгэмд хамааралтайг олно уу? \3 оноо\
- A. Тодорхой институтууд бий болж, гэр бүлийн гүйцэтгэдэг үүргийг боловсролын институт голлон гүйцэтгэх болсон
B. Хөдөлмөрийн хуваарь илүү боловсронгуй болж, арми, шашин, улс төрийн институтууд бэхжсэн
C. Автомат үйлдвэрлэл, компьютер, мэдээллийн технологи хөгжсөн
D. Шинжлэх ухаан, технологийн институтууд давамгайл нөлөө үзүүлсэн
E. Оюуны хөдөлмөрт тулгуурлаж, анги давхрааны ялгаа гүнзгийрсэн
10. Хүн бол дээд хөгжилтэй амьтдаас үндсээрээ ялгаатайг заахдаа түүний хөдөлмөрлөдөг, сэтгэдэг, ярьдаг, маш нарийн бүтэц бүхий уураг тархитай байдаг шинжийг хамтад нь нэгтгэн чухалчилж буй бол доорх аргуудын алиныг нь онцолсны үр дүн бэ? \3 оноо\
- A. Дедукци
B. Индукци
C. Синтез
D. Анализ
E. Аль нь ч биш
11. Нийгмийн олон үйлдлээс ялгагдах нэг чиглэлт, дахин давтагдах үйлдлүүдийн олонлогийг юу гэж нэрлэдэг вэ? \1 оноо\
- A. Нийгмийн шинэчлэл
D. Нийгмийн үзэгдэл
- B. Нийгмийн дэвшил
E. Нийгмийн үйл явц
- C. Нийгмийн хөдөлгөөн
12. Нийгмийн бүтцийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нэг *бие хүний* ойлголт аль нь вэ? \3 оноо\
- A. Хүний нийгэмд эзлэх байр суурь болон эрх, үүргийн нэгдлийг илэрхийлсэн ойлголт
B. Статусаар нөхцөлдсөн бөгөөд хүлээлт бүхий зан үйл, үйлдэл юм
C. Нийгмийн харилцааны эзэн, нийгмийн шинжийг эзэмшсэн, иргэншсэн хүнийг хэлнэ
D. Дахин давтагдашгүй өвөрмөц шинж бүхий хүнийг хэлнэ
E. Зөв хариулт алга
13. Эхнэр, нөхөр тэгш эрх мэдэлтэй байдаг гэр бүлийн хэлбэр аль нь вэ? \3 оноо\
- A. Нуклеар гэр бүл
D. Матриархаль гэр бүл
- B. Өргөжсөн гэр бүл
E. Патриархаль гэр бүл
- C. Эгилатар гэр бүл
14. “Хүн бол улс төрийн амьтан ” гэж хэн тодорхойлсон бэ? \1 оноо\
- A. Д.Истон
B. Ф.Бро
C. Н.Макиавелли
D. Аристотель
E. Х. Лассуэл
15. Аль бодомж нь буруу вэ? \1 оноо\
- A. Засаглалын нөөц гэдэг нь засаглалын эзлэхүүн, цаг хугацаа, орон зай юм
B. Засаглалын хэмжээ гэдэг нь ямар нэгэн засгийн нөлөө, ач холбогдол, цар хүрээ, хэм хэмжээг тодорхойлох үзүүлэлт юм
C. Засаглалын эзлэхүүн гэдэг нь хичнээн тооны засаглал хэн нэгний буюу ямар нэгэн байгууллагын гарт төвлөрч байгааг харуулдаг
D. Засаглалын цаг хугацаа гэдэг нь тухайн засаглалын оршин тогтнох хугацаа
E. Засаглалын орон зай гэдэг нь тодорхой хэмжээтэй газар нутагт засаглалын үйл ажиллагаа үр ашигтай явагдана гэсэн үг
16. Эрх мэдлийн хэлбэрүүдийг харилцааны төрлөөр нь зөв харгалзааг тогтооно уу \1 оноо\

1	Албадлагын хүч хэрэглэх	A	Төр, иргэн 2-ын хоорондын харилцаа нь гэрээний хэлбэрээр илрэх
2	Наймаалцах	B	Иргэн, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах
3	Үүрэг үүсгэх	C	Иргэн хүн бүр хууль дүрмэнд захирагдах

- A. 1A, 2B, 3C
B. 1B, 2C, 3A
C. 1B, 2A, 3C
D. 1C, 2B, 3A
E. 1C, 2A, 3B

17. Монголын эзэнт гүрний үед засаглалын ямар легитим шинжийн хэв маяг ноёрхож байсан бэ? \1 оноо\
- A. Хууль ёсны легитим шинж
B. Уламжлалт легитим шинж
C. Харизмат легитим шинж
D. А ба В хариулт зөв
E. Аль ч легитим шинжид хамаарахгүй
18. Эрх мэдлийг гүйцэтгэж буй чиг үүргээр нь юу гэж ангилдаг вэ? \1 оноо\
- A. Ардчилсан ба ардчилсан бус
B. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх
C. Бага, дунд, өргөн
D. Гэр бүлийн, цэргийн, намын
E. Эдийн засгийн, мэдээллийн, албадлагын
19. Улс төрийн тогтолцооны оролтын илрэл аль нь вэ? \1 оноо\
- A. Шийдвэр үйлдэл
B. Эргэх холбоо
C. Хувиргалт
D. Шаардлага дэмжлэг
E. Гарц
20. Улс төрийн системд сонирхлыг илэрхийлэх үйл ажиллагаа явуулдаг байгууллагыг нэрлэнэ үү? \1 оноо\
- A. Улс төрийн нам
B. Төр /УИХ, ЗГ.м/
C. Төрийн бус байгууллага
D. Хэвлэл, мэдээллийн байгууллага
E. Дээрх бүгд
21. Гэр бүлийн захирах, захирагдах ёсны үр дүн, дуурайллаар төр үүссэн гэж үздэг эцгийн эрхт ёсны онолын төлөөлөгчид аль нь вэ? \1 оноо\
- A. С.Августин, Фома Аквинский
B. Конфуций, Аристотель, Р.Фильмер
C. К.Маркс, Ф.Энгельс, В.И.Ленин
D. Цицерон, Г.Гроций, Л.В. Хэллер
E. Е. Дюринг, Л.Гумплович, К.Каутский
22. Засгийн эрхийн төлөө эрмэлзэж, улс төрийн ажиллагаа явуулдаг, тодорхой зохион байгуулалттай улс төрийн байгууллагыг юу гэж нэрлэдэг вэ? \2 оноо\
- A. Үйлдвэрчний байгууллага
B. Төр
C. Төрийн бус байгууллага
D. Нам
E. Сүм хийд
23. Улс төрийн эрх мэдлийн дээд хэлбэрийг юу гэж нэрлэдэг вэ? \1 оноо\
- A. Нийтлэг эрх мэдэл
B. Засаглал
C. Нийт нутаг дэвсгэр
D. Орон зай
E. Хүн ам
24. Доорх өгөгдлийн аль нь 1992 оны “Үндсэн хууль” –ийн заалт биш вэ? \2 оноо\
- A. Монгол улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд Найрамдах улс мөн
B. Хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална
C. Монгол улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн
D. Үндсэн хуульт төрд нэг л дээд эрх мэдэл байна
E. Монгол улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ
25. Шүүх засаглалын бүрэн эрхэд хамаарах нь аль вэ? \3 оноо\
- A. Гадаад харилцаанд улсаа төлөөлж гэрээ байгуулах
B. Засгийн газрыг огцруулах
C. Үндэсний аюулгүй байдлыг тэргүүлэх
D. Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих
E. Төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм соёлын байгууллагыг удирдах
26. Улс төрийн ардчилсан дэглэмийн шинжийг олж тэмдэглэнэ үү? \1 оноо\
- A. Нийтийн амьдралыг шийдвэрлэх гол хөшүүрэг механизм төрийн мэдэлд байдаг
B. Иргэдийн бие даасан байдлыг дэмждэг, төрөөс хувь хүний амьдралд орж хутгалдахыг үгүйсгэдэг
C. Хуулийг батлан гаргахад зөвхөн гүйцэтгэх засаглал нөлөөлдөг
D. Нийгэмд ашигтай гэж үзсэн аливаа шийдвэрийг төр ямар ч арга хэрэглэн хэрэгжүүлж болно
E. Нийгмийн амьдралын бүхий л хүрээнд төрийн үүрэг ролийг дээшлүүлэх

27. Монгол улсын үндсэн хуульд тус улсын төрийн байгууламжийг юу гэж тодорхойлсон бэ? \2 оноо\
- A. Холбооны улс
D. Холбооны ба нэгдмэл улс
- B. Нэгдмэл улс
E. B ба C хариулт зөв
- C. Холимог улс

28. Эдийн засгийн ямарч тогтолцооны үед байнга тулгарч байдаг мөнхийн асуудал юу вэ? \1 оноо\
- A. Мөнгөний ханш
D. Хязгаарлагдмал нөөц
- B. Эдийн засгийн өсөлт
E. Татвар
- C. Ажилгүйдэл

29. Нийлүүлэлтийн хууль нь тухайн барааны үнэ өсөх үед хэрхэн илрэх вэ? \1 оноо\
- A. Нийлүүлэлт хэвийн үед
C. Нийлүүлэлт өссөнөөр
E. Нийлүүлэлт хэвийн явагдсанаар
- B. Нийлүүлэлтийн хэмжээ буурснаар
D. Нийлүүлэлт буурснаар

30. Дараах тохиолдлуудын алинд нь бараа, үйлчилгээний хомсдол үүсдэг вэ? \1 оноо\
- A. Эрэлт < нийлүүлэлт
D. A ба B хариулт зөв
- B. Эрэлт > нийлүүлэлт
E. Аль нь биш
- C. Эрэлт = нийлүүлэлт

31. Алдагдсан боломжийн өртөг гэж юу вэ? \2 оноо\
- A. Энэ бол цаг алдсанаас үүдсэн өртөг юм
B. Энэ бол үйлдвэрлэлийн нууцаа алдсанаас үүдсэн өртөг юм
C. Энэ бол нөөцөө алдсанаас үүдсэн өртөг юм
D. Энэ бол орхигдсон хувилбарын өртөг юм
E. Энэ бол сонгогдсон хувилбарын өртөг

32. Мөнгөний мөн чанар, гүйцэтгэх үүргийг зөв холбон тэмдэглэнэ үү? \2 оноо\

1	Өртгийн хэмжүүр	A	Мөнгө нь бүх төрлийн бараа үйлчилгээтэй солигдох чадвартай, иймээс хүмүүс хадгалдаг
2	Гүйлгээний хэрэгсэл	B	Мөнгө нь бүх төрлийн бараатай солигдох чадвартай, иймээс барааг мөнгөөр худалдахад татгалздаггүй
3	Хуримтлалын хэрэгсэл	C	Бараа үйлчилгээний өртөг, ашигт чанарыг мөнгөний нэгжээр илэрхийлэх

- A. 1C, 2A, 3B B. 1C, 2B, 3A C. 1A, 2B, 3C D. 1A, 2C, 3B E. 1B, 2C, 3A

33. Хувийн өмч, чөлөөт арилжаа, өрсөлдөөнд тулгуурласан зах зээлийн эдийн засагт хүний “амиа хичээсэн” үйл ажиллагаа зах зээлийн үнээр дамжин нийгмийн буюу улс гүрний хөгжил дэвшилд чиглэгдэнэ гэж “Үндэсний баялаг” номондоо анх бичсэн эрдэмтэн хэн бэ? \1 оноо\
- A. А.Маршалл B. М.Кейнс C. А.Смит D. А.М. Фридман E. К.Маркс

34. Инфляцийг өсөлтийн түвшингээр нь 3 ангилдаг. Тэгвэл үнийн өсөлт хэдэн хувь байвал өндөр түвшинг илэрхийлж байна вэ? \2 оноо\
- A. Жилийн үнийн өсөлт 10%-иас хэтрэхгүй
C. Жилийн үнийн өсөлт 200%-иас дээш
- B. Жилийн үнийн өсөлт 10-200%
D. Жилийн үнийн өсөлт 0%
- E. Дээрх бүгд

35. Төгс бус өрсөлдөөний зах зээлийг тэмдэглэнэ үү? \2 оноо\
- A. Олон борлуулагч, худалдан авагчтай зах зээл
B. Цөөн тооны том борлуулагч өрсөлддөг зах зээл
C. Зах зээлд орж гарах нь чөлөөтэй
D. Барааны үнэ эрэлт, нийлүүлэлтийн харилцаагаар илэрхийлэгддэг зах зээл
E. Бараа үйлчилгээг чөлөөтэй өрсөлдөн худалдаж байгаа зах зээл

36. Хөдөлмөрийн захад өөрийн ажиллах хүчээ худалдахыг санал болгосон ажил идэвхитэй хайж буй хүмүүсийн тоо, хэмжээг юу гэж нэрлэх вэ? \2 оноо\
- A. Ажил эрхлэлт
C. Ажилгүйдэл
- B. Ажиллах хүч
D. Хүний нөөц
- E. A ба B хариулт зөв

37. Татварын тогтолцоог илэрхийлэх жишээнд илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? \2 оноо\
- A. Хүн амын орлогын албан татвар B. Газрын төлбөр
C. Жолоочийн хариуцлагын даатгал D. Замын хураамж E. Аль нь ч биш
38. Орчин үеийн нийгэм дэх бусдаасаа орлого, боловсрол, эрх мэдэл, нэр хүндээрээ ялгаатай байдаг нийгмийн давхраа аль нь вэ? \1 оноо\
- A. Каст B. Боолчлол C. Язгуур D. Анги E. Аль нь ч биш
39. Малчны хүү Ж.Гүррагчаа сансрын нисгэгч, Монгол улсын болон Зөвлөлт холбоот улсын баатар, зэвсэгт хүчний генерал болсон. Энэ нь нийгмийн шилжих хөдөлгөөний ямар төрлийн жишээ вэ? \2 оноо\
- A. Үе хоорондын B. Үе доторх C. Бүтцийн
D. Гэр бүлийн E. Нутаг дэвсгэрийн
40. Нийгмийн давхраажлын шатаар хүмүүс дээшээ, доошоо юмуу хэвтээ чиглэлээр шилжихийг юу гэж нэрлэх вэ? \1 оноо\
- A. Байр суурь үл өөрчлөгдөх шилжилт B. Бүтцийн шилжих хөдөлгөөн
C. Нийгмийн шилжих хөдөлгөөн D. Газар зүйн шилжих хөдөлгөөн
E. Үе хоорондын шилжих хөдөлгөөн
41. Хаалттай нийгмийн давхраажлын хэв маяг аль нь вэ? \1 оноо\
- A. Каст B. Боолчлол C. Язгуур D. Анги E. А ба В, С
42. Нийгмийн эмзэг бүлгийнхний тэтгэвэр, тэтгэмж, халамж болон асрамжийн үйлчилгээ үзүүлэх зэрэг асуудлуудыг хариуцан эрхэлдэг дүүргийн хороодын *ажилтан / албан хаагч /-ыг* нэрлэнэ үү? \1 оноо\
- A. Хорооны засаг дарга B. Хорооны зохион байгуулагч
C. Хорооны нийгмийн ажилтан D. Мэдээллийн ажилтан E. Аль нь ч биш
43. Цэцэрлэгийн багш Хулан хүүхэд төрүүлжээ. Энэ тохиолдолд багш Хулан нь нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу *нийгмийн даатгалын аль төрлийн сангаас* амаржсаны тэтгэмж авах вэ? \2 оноо\
- A. Ажилгүйдлийн даатгалын сангаас B. Эрүүл мэндийн даатгалын сангаас
C. Тэтгэмжийн даатгалын сангаас D. Тэтгэврийн даатгалын сангаас
E. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас
44. Амьдралын боломжийн жишиг гэж тухайн нийгмийн үзэж байгаа хэрэгцээг хангах чадваргүй байдал аль нь вэ? \1 оноо\
- A. Ядуурлын босго B. Үнэмлэхүй ядуурал C. Ядуурлын хэмжээ
D. Харьцангуй ядуурал E. Аль нь ч биш
45. Орчин үеийн боолчлолын хэлбэр аль нь вэ? \1 оноо\
- A. Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр B. Хүний наймаа C. Бэлгийн боолчлол
D. Хүчинд автан гэрлэх E. Дээрх бүгд
46. Соёл гэдэг ухагдахуун анхандаа ямар утгыг илэрхийлж байв? \1 оноо\
- A. Хөрс боловсруулах, газар тариалан эрхлэх B. Үйлдвэрлэлийн технологи боловсруулах
C. Оюун ухааны үйл ажиллагаа D. Сургалтын үйл явц
E. Эдгээрээс өөр
47. Дагуул соёлын жишээ аль нь вэ? \1 оноо\
- A. Бичгийн соёл B. Ардын дуу C. Ярианы соёл D. Харилцааны соёл
E. Залуучуудын соёл

48. Монголын уламжлалт соёлын бүрэлдэхүүнд хамаарах зүйл аль нь вэ? \1 оноо\
 A. Гар утас B. Эстрад дуу C. Өрнийн соёл D. Гадаад хэл E. Уртын дуу
49. Оюуны соёлын элементүүдийг дурдахдаа илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? \1 оноо\
 A. Хэл яриа B. Домог C. Зан заншил D. Эрх мэдэл E. Мэдлэг
50. Үндэсний соёлыг хэн бүтээж байна, ямар түвшний соёл байна гэдгээс хамааруулаад \1 оноо\
 хэлбэрүүдэд хуваадаг.
 A. Дагуул ба сөрөг соёл B. Ардын, элитийн, дагуул соёл
 C. Ардын, элитийн, нийтийн соёл D. Элитийн, нийтийн, дагуул соёл
 E. Нийтийн, ардын, дагуул соёл
51. Соёлын дүрсүүдийг харгалзах утгатай нь зөв тохируулна уу? \3 оноо\

1	Зонхилогч соёл	A	Нийгмийн тодорхой бүлгийн үнэлэмжээр бий болсон соёл
2	Дагуул соёл	B	Нийгмийн гишүүдийн олонхи нь хүлээн зөвшөөрсөн үнэлэмж, итгэл үнэмшил, уламжлал
3	Сөрөг соёл	C	Зонхилогч соёлтой зөрчилдөж байдаг соёл

 A. 1B, 2C, 3A B. 1B, 2A, 3C C. 1C, 2B, 3A D. 1C, 2A, 3B E. 1A, 2C, 3B
52. Аль нь олон улсын эдийн засгийн харилцааны хэлбэр биш вэ? \1 оноо\
 A. Олон улсын худалдаа
 B. Гадаад хөрөнгө оруулалт
 C. Валютын харилцаа
 D. Улс орнуудын хооронд гэрээ хэлэлцээр байгуулах
 E. Үйлдвэрлэл, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагаа
53. 1957 онд Римийн гэрээний үндсэн дээр байгуулагдсан, эдийн засгийн нэгдэл бүхий эв нэгдэл, энх тайвныг эрхэмлэсэн байгууллага аль нь вэ? (Герман, Англи, Итали, Грек, Испани Румын зэрэг улс орнууд байдаг) \1 оноо\
 A. Зүүн өмнөд Азийн орнуудын холбоо
 B. Европын холбоо /ЕЭЗХН/
 C. АСЕАН-ны бүсийн чуулга
 D. Шанхайн хамтын Ажиллагааны байгууллага
 E. Умард Атлантын Гэрээний байгууллага /НАТО/
54. АНУ-ын “Женерал Моторс” компани олон улсын харилцааны аль субъектэд хамаарах вэ? \2 оноо\
 A. Олон улсын байгууллага B. Төр C. Үндэстэн дамнасан байгууллага
 D. Ард түмэн E. Алинд ч хамаарахгүй
55. Монгол Улсын Их Хурал нь олон улсын харилцааны аль субъектэд хамаарах вэ? \1 оноо\
 A. Олон улсын байгууллага B. Ард түмэн C. Үндэстэн дамнасан байгууллага
 D. Төр E. Алинд нь ч хамаарахгүй
56. Аль нь хүний улс төрийн эрхэд хамаарах вэ? \1 оноо\
 A. Гэрлэх, гэр бүлтэй байх B. Хувийн нууцаа хадгалах
 C. Эрүүл мэндээ хамгаалуулах D. Сурч боловсрох E. Намд гишүүнээр элсэх

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж:

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноо

2.1 Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

a	Баримт бичиг судлах арга	1	Нэг юмуу бүлэг үзэгдлийг тодорхойлох зорилгоор мэдрэхгүйгээрээ дамжуулан сэтгэхүйн түвшинд танин мэдэх
b	Туршилтын арга	2	Судалж буй зүйлийн сонирхсон шинжүүдийг илрүүлэхэд зохиомол нөхцлийг бүрдүүлэн судлах
c	Ажиглалтын арга	3	Бодьгал ба бүлэг хүмүүсийн янз бүрийн харилцаа, шинж чанарыг илрүүлдэг болон анкет, сурвалжлага аргыг хэрэглэдэг
d	Түүхчлэх арга	4	Байгууллагын захиргааны шийдвэр, албан бичиг, төлөвлөгөө, дүрэм журам зэргийг үндэслэн анхдагч мэдээлэл олж авдаг эмпирик арга
e	Асуулгын арга	5	Тухайн үзэгдэл, үйл явдлыг үүсэл, хөгжил, буурал, мөхлийн бүх үйл явцыг дэс дараалан судлах арга

2.2 Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

a	Саналаа нууцаар гаргах зарчим	1	Нэг сонгогч нэг л удаа саналаа өгөх, нэг тойрог дахь сонсогчийн тоо тэгш байх
b	Тэгш эрхийн зарчим	2	Сонсогч хэний ч нөлөөнд автахгүй, зөвхөн өөрийн ухамсартай үйл ажиллагаагаар бие даан саналаа илэрхийлэх
c	Бүх нийтийн зарчим	3	Нийт иргэдийн санал хураалтаар сонгуулийн эцсийн дүн тодорхойлогдох
d	Шууд сонгох зарчим	4	Сонгуульд оролцох, эс оролцох, хэний ч дарамт шахалтад оролгүйгээр саналаа чөлөөтэй илэрхийлэх
e	Чөлөөтэй сонгох зарчим	5	Тухайн улсын сонгуулийн насанд хүрсэн, эрх бүхий нийт иргэн сонгуульд оролцож, саналаа илэрхийлэх боломж

2.3 Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

a	Банк	1	Бараа үйлчилгээг хоорондоо солилцохдоо хэрэглэхээр бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн онцгой төрлийн таваар
b	Төсөв	2	Санхүүгийн нэгдсэн төлөвлөгөө
c	Улсын төсөв	3	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал баталж, дээрх шатны засаг дарга бүрдүүлэн зарцуулдаг
d	Мөнгө	4	Улсын Их Хурал хэлэлцэн баталж, Засгийн газар бүрдүүлэн зарцуулдаг
e	Орон нутгийн төсөв	5	Төр, байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн хооронд байнга хийгдэж байдаг мөнгөний харилцааг хангагч зэх зээлийн дэд тогтолцоо

2.4 Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

a	Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж	1	Ахмад настныг асарч буй иргэнд олгох тэтгэмж
b	Нийгмийн хамгаалал	2	Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгө
c	Нийгмийн даатгалын шимтгэл	3	Нийгмийн бүх гишүүдийн хэвийн амьдрахад шаардагдах эдийн засаг, эрх зүйн нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн төрийн бодлого, үйл ажиллагаа
d	Нийгмийн халамж	4	Мөрдөж буй хууль тогтоомж, журмын дагуу нийгмийн эмзэг бүлэгт хамрагдсан иргэнд нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, тэдгээрийн төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулахад чиглэсэн нийгмийн хамгааллын арга хэмжээ
e	Нийгмийн даатгалын сан	5	Нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор даатгуулагч болон ажил олгогчоос хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын санд төлөх урьдчилсан төлбөр